

# **ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**/ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

ЗАХИАЛАГЧ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

:

СУДЛААЧ:

Б.БАТЦЭЦЭГ

УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН

## **АГУУЛГА**

### **Нэг.Ерөнхий мэдээлэл**

**Хоёр. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:**

- 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах

**Гурав. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:**

- 3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 3.6.Нэмэлт зардлыг тооцох.

**Дөрөв. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:**

- 4.1.Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 4.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.Гарах зардлыг тооцох;
- 4.4.Зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

### **Тав.Хавсралт**

## **ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

/Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/

### **НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийв.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдснаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төсөл нь “нэмэлт, өөрчлөлт” хэлбэрээр бичигдэж байгаа буюу уг харилцаа нь нэгэнт өмнө нь хуулиар зохицуулагдсан харилцаа байх тул шинээр буюу өмнө нь гүйцэтгэж байгаагүй үүрэг болон өмнө гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн байвал тэр хүрээнд хязгаарлан зардал тээгч этгээдүүдийн зардлыг тооцох болно.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийг өргөжүүлсэн үүргийн тухайн өргөжүүлсэн хэсэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2 заалтад “тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо байхгүй бол баримжаалж тооцно”, 4.4.2 дахь заалтад “зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно.” гэснийг тус тус баримтлан адил төстэй ажил, үйлчилгээнд зарцуулсан хугацаа, тохиолдлын тоог баримжаалан тогтоосон болно.

---

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

## **ХОЁР.ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ**

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдснаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь дарааллыг баримтлана. Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нийт дүнг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг шалгах

### **2.1.ИРГЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:**

Энэ үе шатанд Захиргааны ерөнхий хууль<sup>2</sup>д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг бүрчлэн судалж хуулийн төслөөр иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг тогтоох юм.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуульд зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмэх тухай, хуульд үг, өгүүлбэр нэмэх тухай, хуулийн зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах тухай, хуулийн зүйл, хэсэг, заалт дахь үг, өгүүлбэр өөрчлөх тухай, хуулийн зүйл, хэсэг, заалтаас үг, өгүүлбэр хасах тухай, хуулийн бүлэг, зүйл, хэсэг заалт хүчингүй болгох тухай гэсэн багц агуулга бүхий 6 зүйлтэйгээр бичигдсэн байна. Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт, өөрчлөлтийн зарчмын шинжтэй асуудлыг тоймловол:

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссийн хүний эрхийн зөрчлийг шалган тогтоох ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлд хамаарахгүй байхаар, одоо Захиргааны ерөнхий хуулийн Долоодугаар бүлгээр зохицуулж байгаа “Төлөвлөлт” бүлгийг захиргааны актыг зохицуулж буй бүлэгт хамааруулан нэгтгэж, долоодугаар бүлгийг хүчингүй болгох тухай, захиргааны хэм хэмжээний актад шилжилтийн үеийн зохицуулалт хийх болон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай материаллаг зохицуулалт, Захиргааны ерөнхий хуулийн Есдүгээр бүлэг “Гомдол гаргах” гэснийг өргөжүүлж, иргэдээс захиргааны байгууллагад хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг нэгтгэн зохицуулж, уг харилцааг зохицуулж байгаа Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийг<sup>3</sup> хүчингүйд тооцох тухай, захиргааны байгууллагын өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг одоо мөрдөгдөж байгаа хугацаанаас<sup>4</sup> богиносгох, Засгийн газрын зарим шийдвэр, тодруулбал Улсын Их Хурлаас үүрэг болгосны дагуу гүйцэтгэсэн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэхгүй байх тухай өөрчлөлт,

<sup>2</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэл, 2015 оны №15-д нийтлэгдсэн.

<sup>3</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэл, 1995 он, №7-д хэвлэгдсэн.

<sup>4</sup> Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.” гэж, мөн зүйлийн 2-т “Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө.” гэсэн хугацааг тус тус тогтоосон.

Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг Улсын Их Хурлын холбогдох ажлын алба хуульд нийцэж буй эсэхийг хянан бүртгэдэг байх тухай зэрэг зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтийг тусгасан байна.

Дээрх агуулгаас үзвэл иргэдэд хамааралтай зохицуулалт нь Захиргааны ерөнхий хуулийн Есдүгээр бүлэгт тусгагдаж буй иргэд, хуулийн этгээд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргахтай холбоотой зохицуулалт байна. Энэ нь хуулийн төсөлд дараахь байдлаар туссан байна.

д/д	Иргэдэд хамааралтай зохицуулалт	Иргэнд үүрэг үүсгэсэн эсэх
1	<p><b>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт</b>  <b>92 дугаар зүйлийн 92.3, 92.4, 92.5, 92.6, 92.7 дахь хэсэг нэмэх тухай:</b></p> <p>“92.3.Гомдол нь үнэн зөв байна.</p> <p>92.4.Гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр, эсхүл амаар, эсхүл тухайн захиргааны байгууллагын албан ёсны цахим хаягт цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно.</p> <p>92.5.Бичгээр гаргасан гомдолд овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсэг зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсэг зурах боломжгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.</p> <p>92.6.Гомдлыг хоёр, түүнээс дээш тооны иргэд хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.</p> <p>92.7.Амаар гаргах гомдлыг тухайн захиргааны байгууллагын гомдол гаргагчийг хүлээн авах байранд очиж гаргана.”</p>	<p>Энэ нь иргэдийн гомдол гаргах эрхийг баталгаажуулсан боловч уг гомдол нь ямар шаардлага хангасан байх шалгуурыг тогтоосон байна. Гэвч энэ зохицуулалт Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлээр 1995 оноос хойш зохицуулагдсан харилцаа тул иргэнд шинээр үүрэг үүсгээгүй байна.</p>
2	<p><b>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт</b>  <b>93 дугаар зүйлийн 93.3, 93.4, 93.5 дахь хэсэг нэмэх тухай:</b></p> <p>“93.3.Гомдол хянан шийдвэрлэх захиргааны байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэх үүргийг хүлээнэ:</p> <p>93.3.1.иргэн, хуулийн этгээдээс гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангах;</p> <p>93.3.2.харьяаллын дагуу ирсэн гомдлыг заавал хүлээн авах, эрх хэмжээний хүрээнд хянан үзэж үндэслэлтэйгээр шийдвэрлэх;</p> <p>93.3.3.гомдлыг хуульд заасан хугацаанд нь барагдуулах, гомдолд дурдсан төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;</p>	<p>Захиргааны байгууллага, албан тушаалтанд үүрэг үүсгэсэн. Гэвч энэ нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлээр 1995 оноос хойш зохицуулсан харилцаа тул зардал үүсэх боломжтой аль ч субъектэд зардал үүсгэхгүй.</p>

	<p>93.3.4.гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг тогтмол хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, жил бүр нийтэд тайлагнах;</p> <p>93.4.Гомдлыг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, шийдвэрлэлтийн талаарх тайлан мэдээ гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх журмыг Засгийн газар батална.</p> <p>93.5.Энэ хуулийн 93.3 дахь хэсэг нь энэ хуулийн 99<sup>1</sup> дугаар зүйлд заасан өргөдөлд нэгэн адил хамаарна.”</p>	
3	<p><b>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт:</b></p> <p><b>“93<sup>1</sup> дүгээр зүйл.Гомдлыг хүлээн авах, бүртгэх</b></p> <p>93<sup>1</sup>.1.Захиргааны байгууллага гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, гомдол хүлээн авах ажилтан ажиллуулна. Гомдлыг захиргааны байгууллагын ажиллах цагийн хуваарийн дагуу хүлээн авна.</p> <p>93<sup>1</sup>.2.Гомдол гаргагчийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий албан тушаалтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ.</p> <p>93<sup>1</sup>.3.Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн гомдлыг энэ хуулийн 93<sup>1</sup>.2 дахь хэсэгт заасан албан хаагч хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ.</p> <p>93<sup>1</sup>.4.Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд ажлын нэг өдөрт багтаан шилжүүлнэ. Гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхийг хориглоно.”</p>	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд зохицуулсан харилцаа тул энэ нь төрийн байгууллагад хэвшиж тогтсон бөгөөд шинэ үүрэг үүсгээгүй байна гэж үзлээ.</p>
4	<p><b>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт:</b></p> <p><b>93<sup>2</sup> дугаар зүйл нэмэх тухай.</b></p> <p><b>“93<sup>2</sup> дугаар зүйл.Гомдлыг хянан шийдвэрлэхгүй байх</b></p> <p>93<sup>2</sup>.1.Дор дурдсан үндэслэл байвал захиргааны байгууллага гомдлыг хянан шийдвэрлэхгүй байж болно:</p> <p>93<sup>2</sup>.1.1.гомдол нь тодорхой нэр, хаяггүй бол;</p> <p>93<sup>2</sup>.1.2.эрх зүйн чадамжгүй, эсхүл шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд тооцогдсон этгээд эцэг, эх, асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй бол;</p> <p>93<sup>2</sup>.1.3.тухайн захиргааны байгууллагад гомдол гаргагч этгээд уг асуудлаар өмнө хандаж байсан бөгөөд түүнийг шийдвэрлэсэн бол;</p> <p>93<sup>2</sup>.1.4.гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол;</p> <p>93<sup>2</sup>.1.5.гомдол нь энэ хуулийн 92<sup>1</sup> дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол;</p>	<p>Энэ нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлээр зохицуулагдсан харилцаа тул шинээр үүрэг болон зардал үүсгэхгүй.</p>

	93 <sup>2</sup> .2.Энэ хуулийн 93 <sup>2</sup> .1 дэх хэсэгт заасан үндэслэл бий болвол захиргааны байгууллага энэ талаар гомдол гаргагчид мэдэгдэх буюу гомдлын бүртгэлд бүртгэнэ.”	
5	<p><b>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12 заалт</b></p> <p><b>99<sup>1</sup> дүгээр зүйл нэмэх тухай:</b></p> <p><b>“99<sup>1</sup> дүгээр зүйл.Өргөдөл гаргах, шийдвэрлэх</b></p> <p>99<sup>1</sup>.1.Иргэн, хуулийн этгээд нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар саналын шинжтэй, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг талаар хүсэлтийн шинжтэй өргөдлийг захиргааны байгууллагад гаргах эрхтэй.</p> <p>99<sup>1</sup>.2.Захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл нь энэ хуулийн 92<sup>1</sup> дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.</p> <p>99<sup>1</sup>.3.Захиргааны байгууллага энэ хуулийн 93<sup>1</sup> дүгээр зүйлд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдлийг хүлээн авч, бүртгэнэ. Энэ хуулийн 93<sup>2</sup> дугаар зүйлд заасан үндэслэл өргөдөлд нэгэн адил хамаарна.</p> <p>99<sup>1</sup>.4.Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол захиргааны байгууллага энэ хуулийн 94.3 дахь хэсэгт заасан хугацаанд зохих шийдвэрийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.</p> <p>99<sup>1</sup>.5.Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууж олгуулах гэх мэт/-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина.</p> <p>99<sup>1</sup>.6.Саналын шинжтэй өргөдлийг хүлээн авч, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалсны үндсэн дээр зохих арга хэмжээ авах, эсхүл зохих хариуг 60 хоногт багтаан өгнө.”</p>	<p>Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл гаргах эрхийг баталгаажуулсан агуулга бүхий заалт. Өргөдөл гаргах, шийдвэрлэх журам, хугацаа зэргийг зохицуулсан бөгөөд энэ агуулгаараа Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж байгаа харилцаа тул иргэн, хуулийн этгээд, төрд уг зохицуулалт шинэ үүрэг бий болгоогүй буюу зардал үүсгэхгүй болно.</p>

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг бүрчлэн судалж үзэхэд иргэнд шинэ төрлийн үүрэг бий болгоогүй байна. Энэ нь нэг талаас Захиргааны ерөнхий хууль нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах харилцааг зохицуулах буюу захиргааны байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон суурь хууль гэсэн Захиргааны ерөнхий хуулийн өөрийнх нь онцлогтой холбоотой юм.

Хуулийн төслөөр иргэнд шинээр үүрэг үүсгээгүй тул аргачлалд заасан дараагийн алхамыг хийх шаардлагагүй буюу Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь иргэнд зардал үүсгэхгүй гэж дүгнэж байна.

## **ГУРАВ.ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Энэ хэсэгт Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн захиргааны байгууллагатай нийтийн эрх зүйн харилцаанд оролцох явцад тодорхой төрлийг үүрэг гүйцэтгэхийг хуулийн этгээдэд даалгасан буюу шаардсан бол үүний дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах юм.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Нэг бүрийн зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг шалгах;
- Нэмэлт зардлыг тооцох.

### **3.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:**

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Захиргааны ерөнхий хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Үүний тулд Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалт байгаа эсэхийг хуулийн төслөөс судлаж үзэх шаардлагатай.

Хуулийн төслийг судлан үзэхэд хуулийн этгээдэд хамаарал бүхий заалт нь энэ тайлангийн “Хоёр” дахь хэсэгт заасан иргэдэд хамаарал бүхий зохицуулалтуудтай давхцаж байна. Өөрөөр хэлбэл өргөдөл, гомдол гаргах эрхийг хуулийн этгээдэд иргэний нэгэн адил хамааралтайгаар хуулийн төсөлд тусгасан байна. Энэ нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар бий болгосон хийдлийг залруулах зорилгоор тусгагдсан байна.

Хэдийгээр Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар “иргэд”-ийн өргөдөл, гомдолд хамааралтай байхаар зохицуулагдсан боловч төрийн байгууллагын хувьд хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдлыг мөн уг хуульд заасан журам, хугацааны дагуу шийдвэрлэж ирсэн байна.

Нөгөө талаас Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дэх хуулийн этгээдэд хамааралтай зохицуулалт нь хуулийн



этгээдийн захиргааны байгууллагад хандан өргөдөл, гомдол гаргах эрхийг баталгаажуулсан бөгөөд хуулийн этгээдэд үүрэг үүсгээгүй байна.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу хуулийн этгээдэд үүсгэсэн үүргийг тогтоох үед хуулийн төсөл нь хуулийн этгээдэд үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

## **ДӨРӨВ.ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь дарааллыг баримтлах болно. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрийг тогтоох
- Уг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцоох
- Зардлын төрлүүдийг нэгтгэн тооцох
- Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

### **4.1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:**

Энэ хэсэгт хуулийн төслийн зохицуулалтыг уншиж судлах замаар тодорхой үүрэг хүлээж буй байгууллага байгаа эсэхийг тодорхойлж, уг байгууллага нь ямар үүрэг буюу ажил үйлчилгээ хуулийн төслийн дагуу гүйцэтгэхээр болж байгааг хуулийн төслөөс тогтоох юм.

Гүйцэтгэх үүрэг гэдэгт хуулийн төслөөр төрийн холбогдох байгууллагад даалгасан бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж буй ажил үйлчилгээг ойлгох юм.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан үзэж дараахь шинэ төрлийн буюу зардал үүсгэх боломжтой үүргийг бий болгосон байна.

<b>Хуулийн төслийн зохицуулалт</b>	<b>Үүрэг хэрэгжүүлэх байгууллага</b>	<b>Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ</b>
Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт “64.2.Ерөнхийлөгч, Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлнэ. Ерөнхийлөгч, Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний актыг энэ хуулийн 60.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах ажиллагааг Улсын Их Хурлын холбогдох ажлын алба хариуцан гүйцэтгэнэ.”	Улсын Их Хурлын холбогдох ажлын алба	Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянаж, бүртгэх

## **4.2.АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОДОРХОЙЛОХ:**

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан үзэж 4.1 дэх шатанд ямар төрийн байгууллага, ямар үүрэг хүлээж байгаа тогтоосон болно. Энэ үе шатанд дээрх үүргийг хэрэгжүүлэхийн тулд тухайн төрийн байгууллагад хэдий хэмжээний хүний нөөц шаардлагатайг тогтоох юм.

Хүний нөөцийг тогтоох ажиллагаа нь мөн тодорхой дарааллын дагуу хийгдэх юм. Үүнд:

- Үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хугацааг тодорхойлох
- Тохиолдлын тоог тодорхойлох
- Шаардагдах нийт ажлын цагийг гаргах гэсэн дарааллаар хүний нөөцийг тооцоолох болно.

Тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацааг болон уг ажил үйлчилгээг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог /цаашид “тохиолдлын тоо” гэх/ ашиглан шаардагдах нийт ажлын цагийг тооцоолох юм.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагын адил, төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага хийсний дүнд тодорхойлсон болно.

Тохиолдлын тоог 2017 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан зарлиг, Монгол Улсын Засгийн газрын баталсан тогтоолыг нэг бүртчлэн судалж<sup>5</sup>, түүн дотор захиргааны хэм хэмжээ тогтоосон акт хэдийг баталсан байгаад үндэслэн гаргасан болно. Уг судалгааг хавсралт хэсгээс үзнэ үү. 2017 онд Ерөнхийлөгч 6 захиргааны хэмжээний актын шинжтэй зарлиг гаргасан бол Засгийн газрын шийдвэр нийт 51 шийдвэр захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулсан байна. Иймд дээрх хоёр субъектыг баталсан захиргааны хэм хэмжээний актын тоо нийт тоймолж 60 байхаар тогтох бөгөөд хэм хэмжээний актыг хянаж бүртгэх, ажиллагааг хийх явцад нэг актыг 2 дахин хянах явдал байдаг талаар уг чиг үүргийг захиргааны бусад байгууллагуудын баталсан хэм хэмжээний актыг хянаж, бүртгэх хүрээнд хийж буй Хууль зүй, дотоод хэргийн яамны холбогдох нэгжийн тайлан илтгэж байна.

Иймээс уг нэмэлт ажиллагаа хийхэд шаардлагатай хугацааг мөн тооцоолох шаардлагатай гэсэн үе юм.

---

<sup>5</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн тойм судалгааг хавсралт хэсгээс үзнэ үү.

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Үүргийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Нийт шаардлагатай хугацаа
Улсын Их Хурлын холбогдох ажлын алба	Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянаж бүртгэх	Хуульд заасан бүрдэл хангагдсан эсэхийг шалгах	4 цаг	60	240 цаг
		Захиргааны хэм хэмжээний актыг уншиж судлах	16 цаг	60	960 цаг
		Захиргааны хэм хэмжээний актад тавигдах шалгуурын дагуу шалгах	4 цаг	60	240 цаг
		Захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгогдсон болон бусад холбогдох хууль тогтоомжийг судлах	8 цаг	60	480 цаг
		Холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, байгууллагад хүргүүлэх	8 цаг	60	480 цаг
		Бүртгэхээр шийдвэрлэсэн бол захиргааны хэм хэмжээний актын санд бүртгэж, дугаар авах	1 цаг	60	60 цаг
		Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтлүүлэхээр хүргүүлэх	10 мин	60	10 цаг
		Захиргааны хэм хэмжээний акт хуульд заасан шаардлага хангаагүй бол дахин хянах	40 цаг <sup>6</sup>	15 <sup>7</sup>	600 цаг

<sup>6</sup> Шаардлага хангаагүй тохиолдолд баталсан этгээдэд буцааж, дахин ирүүлэхийг зөвлөдөг бөгөөд дахин ирүүлвэл шинээр ирсэнтэй адил бүх ажиллагааг хийх тул нийт 40 цагаар авч үзэв.

<sup>7</sup> Шаардлага хангаагүй тохиолдолд дахин ирүүлэхэд тохиолдлын тоог 15-аар тогтоосон нь одоо Захиргааны ерөнхий ауулийн дагуу захиргааны актыг хянаж, бүртгэх үйл ажиллагааг гүйцэтгэж буй Хууль зүй, дотоод хэргийн яамны холбогдох нэгжийн туршлагаас судалж, нийт ирүүлж байгаа актын 4/1-г буцаах магадлалтай гэж үзэж тохиолдлын тоог 15-аар авав.

		Бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хяналт, шинжилгээ хийх	200 цаг	1 <sup>8</sup>	200 цаг
<b>НИЙТ</b>			41 цаг 10 мин	60	3270 цаг

Хуулийн төсөлд шинээр тусгагдсан үүргийг хэрэгжүүлэхэд нийт шаардлагатай цаг хугацааг Хөдөлмөрийн тухай хуульд<sup>9</sup> заасан ажиллах цагийн горимтой харьцуулах замаар шаардлагатай хүний нөөцийг тогтоох юм. Ингэхдээ нэг жилд ажиллах цаг гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлах юм. Нэг жилд ажиллах цагийг доорхийн дагуу тооцон гаргах болно.

1 жил = 200 ажлын өдөр<sup>10</sup>

1 жилд ажиллах өдөр =  $200 \times 8 \text{ цаг}^{11} = 1600 \text{ цаг}$  нэг албан хаагч нэг жилд ажилладаг цаг.

**ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ = ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАРЦУУЛАХ ХУГАЦААГ НЭГ ЖИЛД АЖИЛЛАХ ХУГАЦААНД ХУВААСАНТАЙ ТЭНЦҮҮ**

Дээрх томъёоны дагуу Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтад заасан Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянаж, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тооцвол:

**ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ = ШААРДЛАГАТАЙ ЦАГ / ЖИЛД АЖИЛЛАХ ЦАГ**

**ШААРДЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ =  $3270 \text{ цаг}^{12} / 1600 \text{ цаг}^{13} = 2,04$  ажиллах хүч**

<sup>8</sup> Захиргааны ерөнхий агуулийн 6 дугаар бүлэгт зааснаар хяналт, шинжилгээ үнэлгээг жилд 1 удаа хийхээр заасан тул тохиолдлын тоог 1 байхаар авсан.

<sup>9</sup> Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1999 оны №25-д нийтлэгдсэн.

<sup>10</sup> Нэг жилийн хуанлийн 365 хоногоос хуульд заасан нийтээр амрах баярын өдөр, ээлжийн амралт, хагас, бүтэн сайн зэргийг хасч бодитойгоор ажиллах өдрийг тогтоосны дагуу 200 өдөр ажиллана гэж тооцоолдог.

<sup>11</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэгт “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна” гэж заасанд нийцүүлэн өдөрт ажиллах цагийг тогтоосон.

<sup>12</sup> Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянах, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт цаг

<sup>13</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн тогтоосон 1 хүний жилд ажиллах цаг

Хуулийн төсөлд тусгагдсан чиг үүрэг	Чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа /цагаар/	Хөдөлмөрийн хуульд заасны дагуу 1 ажилтны жилд ажиллах цаг	Чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжид нэмэгдэж буй ачаалал
Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянаж бүртгэх	Улсын Их Хурлын холбогдох нэгж	3270 цаг	1600 цаг	2,04 ажиллах хүч

### 4.3.ГАРАХ ЗАРДЛЫГ УРЬДЧИЛАН ТООЦООЛОХ

Төрд нэмэгдэж байгаа чиг үүрэгтэй холбоотойгоор зардал гарах нь өмнөх үе шатанд тогтоогдсон тул ямар төрлийн зардал гарахыг цааш үргэлжлүүлэн тооцоолох юм. Төрд үүсэх зардлыг дараахь бүлэг болгон ангилж тооцоолно. Үүнд:

- Хүний нөөцийн зардал
- Материаллаг зардал
- Бусад шууд гарах зардал

**Хүний нөөцийн зардал** гэдэгт нэмэгдэж буй хүний нөөцөд олгох цалин хөлс зэргийг багтаана.

Өмнөх үе шатанд тогтоосны дагуу хуулийн төслөөр бий болгож буй чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурлын холбогдох ажлын албаны нэгжид 2 орон тоотой шаардлагатай гэж тогтоосон болно.

Аргачлалд зардлын тооцоо хийхэд ашиглах холбогдох суурь тоог албан ёсны эх сурвалжаас авсан тоо баримтыг эх сурвалж болгохоор заасан тул Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг төрийн албан хаагчид ногдох хүний нөөцийн хувьсах зардал болон материаллаг зардлын талаарх мэдээллийг авах шаардлагатай байсан боловч одоогоор Сангийн яамнаас нэгдсэн байдлаар гаргасан тоо байхгүй байна. Сангийн яам нь Төсвийг тооцоолохдоо тухайн байгууллагын чиг үүргийн онцлог, одоо байрлаж байгаа байрны байдал зэргээс хамааран байгууллага, байгууллагад харилцан адилгүй байдлаар хувьсах зардлыг тооцоолдог талаар мэдээлсэн болно.

Мөн энэ талаар Засгийн газрын 2002 оны 120 дугаар “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” тогтоолоор “Орон нутагт оршин суугаа 1000 хүнд ногдох удирдлагын хувьсах зардлын жишиг нормативыг Улаанбаатар хот 3300 төгрөг”-өөр тогтоосон боловч энэ нь 16 жилийн өмнө батлагдсан тул жишиг болгон ашиглах боломжгүй бөгөөд үүнийг мөрддөггүй байна. Дээрх тогтоолын дагуу төрийн албан хаагчийн өрөө талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийг тогтоож өгсөн нь төрийн албан хаагчтай холбогдон гарах “материаллаг зардал”-ыг тооцоолоход ашиглаж болохоор байна.

Иймд нэг албан хаагчид оногдох материаллаг зардлыг тооцоолоход Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг удирдлага болгохын

зэрэгцээ зардал тооцогдож байгаа байгууллагын санхүүгээс төсөв төлөвлөхөд ашигладаг норм, нормативыг харгалзан үзэх нь зүйтэй.

#### **4.3.1. Хүний нөөцийн зардал:**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай”, Засгийн газрын 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтаар “Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-г шинэчлэн тогтоосныг хүний нөөцийн зардлыг тооцоолоход ашиглав.

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” хавсралтад зааснаар Улсын Их Хурлын Тамгын газрын референт нь АА-6 гэсэн албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарч байгаа бөгөөд Засгийн газрын 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтад зааснаар АА-6 албан тушаал нь цалингийн сүлжээний шатлалаас хамааран 691610-864211 төгрөгийн цалинг сард олгохоор заасан байна.

Нийт шаардлагатай хүний нөөцийн зардлыг дараахь томъёогоор олох юм.

<b>Хүний нөөцийн зардал = сарын цалин х 12 сар х шаардлагатай хүний нөөц</b>
--

Үүнийг Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу шаардлагатай хүний нөөцийн зардлыг тооцоолоход ашиглавал:

<b>Хүний нөөцийн зардал = 779338<sup>14</sup> х 12 сар х 2 хүн = 18.704.112 төгрөг</b>
--

#### **4.3.2. Материаллаг зардал:**

Материаллаг зардлыг тооцоолоход Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-ийг баримтлан үзвэл нэг албан хаагчийг дагалдан дараахь материаллаг зардал гарахаар байна.

**“Дөрөв. Дэс түшмэл /түүнтэй адилтгах албан тушаалтан/**

Тавилга, хэрэгслийн төрөл

Тоо хэмжээ

1. Хувцасны өлгүүр (шүүгээ)

1

